



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУЛГАН СУМЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН 2022 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БУА-2023/162/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

БУЛГАН ХОТ

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас:70342580

Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас:70342716

Цахим хаяг: enkhthoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном

Утас:70342495

Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

᠒᠐23.02.24 № ᠘3᠖  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

БУЛГАН СУМЫН ТОХИЖИЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН ДАРГА  
А.ГАНБОЛД ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нэмэлт санхүүжилтийн дансаар авто замын арчлалт хийх зориулалтаар аймгийн авто замын сангаас олгосон 50,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 12,504.9 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан,

Байгууллагын даргын тушаал шийдвэргүй, дотоод журамд заасан үндэслэлд нийцэхгүй 2,687.8 мянган төгрөгийн тэтгэмж олгосон,

Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалан байгууллагын эзэмшлийн авто машины бүртгэл дээрх 350.0 мянган төгрөгийн торгуулийг төсвөөс төлсөн,

Тайлант хугацаанд нийт 8,247.5 мянган төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зэрэг зөрчил нь сонгосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "Тохолдсон байх", "Үнэн зөв байдал", "Толилуулга, ба тодруулга", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

006020261

Тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээний хэрэгжүүлэхээр 596,594.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж 95.9 хувийг зарцуулсан байна.

#### **Аудитын гол асуудал**

2022 онд орон нутгийн төсвөөс 94454.7, аймгийн ОНХС-аас 94454.7, нэмэлт санхүүжилтийн дансаар 67082.3 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, батлагдсан төсвөөс хот доторх ногоон байгууламж арга хэмжээний төсвөөс 24,150.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт авсан байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл ажилчидтай холбогдсон авлагын 2449.2 мянган төгрөгийг бүрэн барагдуулж, тайлант онд ХХОАТ-ын 65.3 мянган төгрөгийн авлага нэмэгдэж 70.4 мянган төгрөгийг үлдэгдэлтэй, өглөгийг дансны эхний үлдэгдэл 6021.2 бүрэн барагдуулж, тайлант онд цалингийн 103.3, хүмүүс өгөх 33.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2022 санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>90,892,156.00</b>	<b>35,094,170.40</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,640,672.00	70,370.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,449,203.00	65,345.03
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	191,469.00	5,025.37
3351	Байгууллагаас авах авлага	-	25.37
3352	Хувь хүмүүсээс авах авлага	191,469.00	5,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	88,251,484.00	35,023,800.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	72,000.00	115,000.00
35110	Тусгай зориулалттай материал	72,000.00	115,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	88,179,484.00	34,908,800.00
35410	Бичиг хэргийн материал	206,000.00	176,000.00
35420	Аж ахуйн материал	23,041,250.00	18,414,550.00
35430	Сэлбэг хэрэгсэл	11,307,400.00	325,000.00
35440	Түлш, шатах тослох материал	654,070.00	120,000.00
35450	Барилгын засварын материал	41,876,560.00	2,846,000.00
35460	Хүнсний материал	10,583,104.00	13,027,250.00
35470	Бусад хангамжийн материал	511,100.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,697,114,080.52</b>	<b>7,291,560,653.97</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	8,697,114,080.52	7,291,560,653.97
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,740,474,080.52	6,334,920,653.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,195,561,469.18	1,195,561,469.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(153,075,991.56)	(298,735,448.77)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	650,706,102.00	622,366,102.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(295,734,654.14)	(356,326,980.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,090,383,611.55	1,089,798,641.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(236,161,347.59)	(532,047,922.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	303,389,700.00	301,689,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(294,237,834.14)	(296,431,150.27)
39209	Зам, гүүрийн байгууламж	2,799,991,700.15	2,799,991,700.15
39210	Хуримтлагдсан элэгдэл	(822,758,329.41)	(1,036,550,799.83)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	388,889.00	388,889.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(268,981.42)	(356,481.40)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	771,354,945.90	771,354,945.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,343,015,534.28	3,421,666,913.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(612,080,733.28)	(1,347,448,923.66)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	956,640,000.00	956,640,000.00
39301	Програм хангамж	650,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(150,000.00)	300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	956,140,000.00	956,140,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>8,788,006,236.52</b>	<b>7,326,654,824.37</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,021,187.92</b>	<b>137,255.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	6,021,187.92	137,255.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	6,021,187.92	137,255.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	278,274.92	103,335.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,144,813.00	20.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	598,100.00	33,900.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	598,100.00	33,900.00

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,781,985,048.60</b>	<b>7,326,517,569.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,781,985,048.60	7,326,517,569.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,103,290,133.50	5,103,290,133.50
51101	Өмч: - төрийн	5,103,290,133.50	5,103,290,133.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,293,506,590.13	1,838,624,080.90
51210	Өмнөх үеийн үр дүн	3,293,506,590.13	3,294,091,560.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,455,467,479.23)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	385,188,324.97	384,603,354.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,788,006,236.52</b>	<b>7,326,654,824.37</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,426,543,283.59</b>	<b>829,696,139.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>632,895,883.59</b>	<b>190,169,759.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	632,895,883.59	190,169,759.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	632,895,883.59	190,169,759.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,250,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	630,645,883.59	190,169,759.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>793,647,400.00</b>	<b>639,526,380.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	94,454,700.00	94,454,700.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	94,454,700.00	94,454,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	68,953,300.00	67,082,280.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,953,300.00	52,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,542,280.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,540,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	630,239,400.00	477,989,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	630,239,400.00	477,989,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,114,908,026.64</b>	<b>2,282,845,294.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,114,908,026.64</b>	<b>2,282,845,294.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,114,738,329.64	2,280,122,427.82
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	14,828,300.00
210408	Бараа материал акталсны зардал	-	14,828,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	789,709,042.64	706,407,646.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	789,709,042.64	706,407,646.04
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	325,029,287.00	1,558,886,481.78
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	325,029,287.00	1,558,886,481.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	169,697.00	2,722,866.64
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	169,697.00	2,722,866.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	169,697.00	2,722,866.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>311,635,256.95</b>	<b>(1,453,149,155.46)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	32,493,533.56	2,318,323.77
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	32,493,533.56	2,318,323.77
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(32,493,533.56)	(2,318,323.77)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>279,141,723.39</b>	<b>(1,455,467,479.23)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>795,897,400.00</b>	<b>639,526,380.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,250,000.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,250,000.00	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2,250,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,250,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>793,647,400.00</b>	<b>639,526,380.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	94,454,700.00	94,454,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	94,454,700.00	94,454,700.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	68,953,300.00	67,082,280.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,953,300.00	52,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,542,280.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,540,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	630,239,400.00	477,989,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	630,239,400.00	477,989,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>795,897,400.00</b>	<b>639,526,380.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>795,897,400.00</b>	<b>639,526,380.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>795,727,703.00</b>	<b>636,803,513.36</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	774,693,453.00	636,803,513.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	774,693,453.00	636,803,513.36
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,034,250.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,034,250.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>169,697.00</b>	<b>2,722,866.64</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	169,697.00	2,722,866.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	169,697.00	2,722,866.64
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	5,103,290,133.50	420,223,625.77	2,979,329,565.86	8,502,843,325.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	35,035,300.80	35,035,300.80
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,103,290,133.50</b>	<b>420,223,625.77</b>	<b>3,014,364,866.66</b>	8,537,878,625.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(35,035,300.80)	-	(35,035,300.80)

C07	Тайлант үеийн үр дүн	-	-	279,141,723.39	279,141,723.39
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,103,290,133.50</b>	<b>385,188,324.97</b>	<b>3,293,506,590.13</b>	8,781,985,048.60
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,103,290,133.50</b>	<b>385,188,324.97</b>	<b>3,293,506,590.13</b>	8,781,985,048.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	584,970.00	584,970.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,103,290,133.50</b>	<b>385,188,324.97</b>	<b>3,294,091,560.13</b>	8,782,570,018.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(584,970.00)	-	(584,970.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,455,467,479.23)	(1,455,467,479.23)
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,103,290,133.50</b>	<b>384,603,354.97</b>	<b>1,838,624,080.90</b>	7,326,517,569.37

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	596594100.00	572261233.70
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	596594100.00	572261233.70
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	596594100.00	572261233.70
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	596,594,100.00	572,261,233.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	596,594,100.00	572,261,233.70
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	596,594,100.00	572,444,100.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	596,594,100.00	572,444,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	502,139,400.00	477,989,400.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	94,454,700.00	94,454,700.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>71,034,225.00</b>	<b>64,542,279.66</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>71,034,225.00</b>	<b>64,542,279.66</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	71,034,225.00	64,542,279.66
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	71,034,225.00	64,542,279.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,034,225.00	64,542,279.66
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	68,953,300.00	67,082,280.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	68,953,300.00	67,082,280.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,953,300.00	52,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,542,280.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,540,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Булган сумын тохижилт үйлчилгээний анги нь “нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ногоон байгууламж, автозам засвар үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх, дээрх нийтийн үйлчилгээний чиглэлээр болоод гэрэлтүүлэг, хог хаягдлын менежментийг сайжруулах, хамгаалах, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг эрхлэх, нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн үйлдвэрийн автомашин механизм, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, сумын нийтийн үйлчилгээг хөгжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласан байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Булган сумын тохижилт үйлчилгээний анги нь Булган аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/124 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтсээс тус онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,461,351.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	2640.62	70.37	-2,570.25
Бараа материал	88,251.48	35,023.8	-53,227.68
Үндсэн хөрөнгө	8,697,114.08	7,291,560.65	-1,405,553.43
Нийт хөрөнгө	8,788,006.24	7,326,654.82	-1,461,351.42
Өр төлбөр	6,021.19	137.25	-5,883.94
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,781,985.05	7,326,517.57	-1,455,467.48
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,788,006.24	7,326,654.82	-1,461,351.42

**Авлага:** Авлага данс нь оны эхэнд 2640.6, оны эцэст 70.4 мянган төгрөг болж өмнөх оноос 2570.2 мянган төгрөгөөр буурсан нь ажилчдтай холбогдсон авлагын 2449.2 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Бараа материалын оны эхний үлдэгдэл 88251.4, эцсийн үлдэгдэл 35023.8 мянган төгрөг болж өмнөх оноос 53227.6 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 213,082.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 285,999.9 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар 14828.3 мянган төгрөгийн бараа материалыг устгасан байна.

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 11,111,581.9, оны эцсийн үлдэгдэл 11,159,158.4 мянган төгрөг болж өмнөх оноос 47,576.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр хөрөнгө бэлтгээгүй, 77,000.0 мянган төгрөгийн сургуулийн хүүхдийн автобус, гэрэл дохионы 78651.4 мянган төгрөгийн хөрөнгийг төлбөргүй шилжүүлснийг орлогоор бүртгэсэн байна. Тайлант онд аймгийн ИТХ тогтоолоор 105,340.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, байгууллагын даргын тушаалаар 2734.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг акталж устгасан байна.

**Өр төлбөр:** Тайлант оны эхний үлдэгдэл 6021.2 мянган төгрөгийн үлэгдлийн бүрэн барагдуулж тайлант онд шинээр 103.3 мянган төгрөгийн цалингийн өглөг үүссэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 78579.7, орон нутгийн төсвөөс 26340.1 нийт зарлагыг 104919.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 502,139.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 94454.7 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 477,989.4, орон нутгийн хөгжлийн сангаас 94454.7, нэмэлт санхүүжилтээр 67082.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 572261.2 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь орон нутгийн төсвийн санхүүжилтээс 24150.0 мянган төгрөгийг дутуу авсантай холбоотой байна.

*Х201 хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

					/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагаа	65184.8	62304.9	187.9	95.6
2	80214 уран бүтээл хийх зардал	3000.0	3000.0	0	100
3	80802 АО олгос тэтгэмж	9265.4	9147.4	0	98.7
4	83603 нэмэлт	5129.5	1000.0		19.5
5	80111 тогтмол	23647.8	23647.8		100
6	80112 нийтлэг үйлчилгээ	2692.3	2692.2		100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн авто замын сангаас 50,000.0, ЗД нөөц хөрөнгөөс нийтийн тээврийн нөхөн олговорт 8000.0, Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн засвар 3300.0, Аймгийн ЗДТГ-аас баяр наадмын зардалд 3242.3 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авсан байна.

Гүйцэтгэлээр авто замын арчлалт хийх зориулалтаар 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож үүнээс 12.5 сая төгрөгийг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-д "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна." Мөн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8-д "Авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.", Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмын 3.7-д "Авто замын сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний

өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын туслах үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 596,594.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,948.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш зарлагын 9 гүйлгээний 66,319.1 мянган төгрөгийн гүйлгээ байршуулахаас 1 гүйлгээний 6,210.2 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, мөн тайлант онд 67 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тайлант онд завсрын аудит хийгээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1441.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч хэрэгжилтийн тооцон хариуг 2022 оны 03 дугаар сарын 15 тоот албан бичгээр хариу ирүүлж, бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1813.4	1	1800.0	100
Албан шаардлага	4	1044.0	4	1044.0	100
Зөвлөмж	1	0	1	0	100
<b>Нийт дүн</b>					

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 77,300.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулж, 8247.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил 3 зөвлөмж хүргүүлээ.

Үүнд: Үндсэн хөрөнгийн тайланд программ хангамжийн элэгдэл 300.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмжийн элэгдлээр тайлагнасан, мөн үнэ төлбөргүй ирсэн 77.000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн байна.

Аудитаар нийт 30,000.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 18715.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 3037.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын даргын тушаал шийдвэргүй, дотоод журамнд заасан үндэслэлд нийцэхгүй 2687835 төгрөгийн тэтгэмжийг байгууллагын даргаар ажиллаж байсан Н.Баасанжаргалд олгосон байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

2. Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалан байгууллагын эзэмшлийн авто машины бүртгэл дээрх 350000 төгрөгийн торгуулийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

#### 5.2 Албан шаардлага

1. Нэмэлт санхүүжилтийн дансаар авто замын арчлалт хийх зориулалтаар 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож үүнээс 12.5 сая төгрөгийг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-д "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна." Мөн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8-д 'Авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.", Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмын 3.7-д "Авто замын сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

2. Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш зарлагын 9 гүйлгээний 66319149 төгрөгийн гүйлгээ байршуулахаас 1 гүйлгээний 6210207 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, мөн тайлант онд 67 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн тайланд программ хангамжийн элэгдэл 300.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмжийн элэгдлээр тайлагнасан, мөн үнэ төлбөргүй ирсэн 77.000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн байна.	1	77000.0	0	0	1	77000.0	1	77000.0			0	0
									0	0		
Дүн	1	3597.8	0	0	1	3597.8	1	3597.8	0	0	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүл

											сэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын даргын тушаал шийдвэргүй, дотоод журамнд заасан үндэслэлд нийцэхгүй 2687835 төгрөгийн тэтгэмжийг олгосон	1	2687.8	1	2687.8					0	0	0	0
Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалан байгууллагын эзэмшлийн авто машины бүртгэл дээрх 350000 төгрөгийн торгуулийг төсвөөс төлсөн	1	350.0	1	350.0								
Нэмэлт санхүүжилтийн дансаар авто замын арчлалт хийх зориулалтаар 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож үүнээс 12.5 сая төгрөгийг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан байна	1	12504.9			1	12504.9						
Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш зарлагын 9 гүйлгээний 66319149 төгрөгийн гүйлгээ байршуулахаас 1 гүйлгээний 6210207 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, мөн тайлант онд 67 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	6210.2			1	6210.2						
Тайлант хугацаанд нийт 8247.5 төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.	1	8247.5					1	8247.5				
Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 39 төрлийн 993,022.2 мянган төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй, данс бүртгэлээс хасаагүй							1					
Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, чанар хүртээмж, өмч хөрөнгөтэй холбоотой дотоод хяналт шалгалтыг зохион байгуулаагүй							1					
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>30000.5</b>	<b>2</b>	<b>3037.8</b>	<b>2</b>	<b>18715.1</b>	<b>3</b>	<b>8247.5</b>				